



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 29 сарын 29 өдөр

Дугаар 119

Мандалговь

Г

7

Үндсэн хөрөнгө бүртгэх,
Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, 2021 оны 38 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан нийт 2,731,180,416 /хоёр тэрбум долоон зуун гучин нэгэн сая нэг зуун наян мянга дөрвөн зуун арван зургаа/ төгрөгийн үнэ бүхий Залуус хорооллын гадна дулаан, цэвэр, бохир усны шугамыг “Дундговь-Ус” Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоотой Үйлдвэрийн Газар”-ын үндсэн хөрөнгөд бүртгэх, холбоо, цахилгааны шугам сүлжээг хавсралтад заасны дагуу мэргэжлийн байгууллагад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Адъяасүрэн), “Дундговь-Ус” Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоотой Үйлдвэрийн Газар”-ын дарга (О.Бархүү) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон Залуус хорооллын холбоо, цахилгааны шугам сүлжээний байгууламжийг төрийн өмчид шилжүүлэх ажлыг зохих хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлэх;

2.2 Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4 Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
49 дүгээр тогтоолын хавсралт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан
Залуус хорооллын гадна дулаан, цэвэр, бохир усны шугам,
холбоо, цахилгааны шугам сүлжээний мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн дүн	Нийт бүртгэх дүн	Бүртгэх байгууллагын нэр
1	Гадна дулааны шугам	1,448,955,520		
2	Гадна дулааны үзелүүд	25,768,595		
3	Гадна цэвэр ус	133,113,361		
4	Гадна бохир ус	180,055,700		
5	Залуус хорооллын гадна холбоо	193,207,533		
6	Залуус хорооллын гадна холбооны худаг	24,447,640	217,655,173	“Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчт ХХК-ийн Дундговь аймгийн Мэдээлэл Холбооны газар
7	Дэд өртөөний барилга	118,628,052		
8	0.4-6 кв-н гадна кабель шугам	299,603,602		
9	10/04 кв хүчдэлтэй 2*630кВа чадалтай дэд өртөө 1 ком	162,988,941	725,632,067	“Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК-ийн “Дундговь Цахилгаан Түгээх Сүлжээ Салбар”
10	10/0.4кв хүчдэлтэй 2*400кВа чадалтай дэд өртөө 1 ком	144,411,472		
Нийт		2,731,180,416 /хоёр тэрбум долоон зуун гучин нэгэн сая нэг зуун наян мянга дөрвөн зуун арван зургаа/ төгрөг		